

Дундговь аймаг дахь
Төрийн аудитын газар



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ГОВЬ-УГТААЛ СУМЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ
ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДУА-2021/82-ШТА-ГА

Тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон
гүйцэтгэгч Р.Мөнхтогтох

Утас: 70592439,

Аудитын менежер Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

Ахлах аудитор Т.Батсайхан Утас: 7059-3113

Аудитор Ж.Угтахбаяр Утас: 7059-3113

Аудитор Т.Оюун-Эрдэнэ Утас: 7059-3113

Аудитор Б.Гантуяа Утас: 7059-2225

Аудитор Л.Уранбилэг Утас: 7059-3113

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	Товчилсон үгс	3
<u>Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар</u>	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4-5
	Ерөнхий мэдээлэл	5
<u>Дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Мөнхтөгтох</u>	<u>Бүлэг 1. СУМЫН БОДЛОГЫГ ЦОГЦ БАЙДЛААР ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.</u>	6-12
	1.1 Сумын бодлогын баримт бичигт зорилго, зорилтоо оновчтой дэвшүүлээгүй байна.	6-9
<u>Аудитын менежер Х.Наранцацрал</u>	1.2 Сумын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бодитой төлөвлөөгүй байна..	9-12
<u>Ахлах аудитор Т.Батсайхан</u>	<u>Бүлэг 2. ДОТООД ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙГЭЭС БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.</u>	12-24
<u>Аудитор</u>	2.1 Удирдлага, зохион байгуулалт хангалтгүйгээс сумын үйл ажиллагааны хэрэгжилт үр нөлөөгүй байна.	12-18
<u>Ж.Угтахбаяр Т.Оюун-Эрдэнэ Б.Гантуяа Л.Уранбилэг</u>	2.2 Дотоод хяналт хангалтгүйгээс аудитаар илэрч буй алдаа, зөрчил өссөн байна.	19-21
	2.3 Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт хангалтгүй байна.	21-24
<u>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70593208 дугаарын утас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.</u>	Дүгнэлт	25
	Зөвлөмж	26
	Шалгагдагч байгууллагын санал тайлбар	
	Тайлан баталгаажуулах тушаал	
<u>ХАЯГ:</u>		
<u>Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 214 тоот</u>		
<u>2021 оны 08 дугаар сар</u>		

ТОВЧИЛСОН ҮГС

МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
СХС	Сум хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИОТТХ	Иргэний орлого тодорхойлох тайлангийн хуудас
ОНТ	Орон нутгийн төсөв
ХШҮДАХ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
МХС	Мал хамгаалах сан
НББ	Нягтлан бодох бүртгэл
БСШУЯ	Боловсрол, соёл шинжлэх ухааны яам
ЭЭС	Эмийн эргэлтийн сан
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг МУЕА-ын 2021 оны А/28 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын “2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Говь-Угтаал сумын бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, сумын бодлого, төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- ✓ Сумын бодлого, төлөвлөлт үр дүнтэй байгаа эсэх,
- ✓ Бодлого, төлөвлөлтийн хэрэгжилт үр нөлөөтэй байгаа эсэх.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

- ✓ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль /тухайн үед мөрдөгдөж байсан/;
- ✓ Төсвийн тухай хууль;
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- ✓ Дундговь аймгийн болон сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлүүд;
- ✓ Засаг даргын мөрийн хөтөлбөр;
- ✓ Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”;
- ✓ Холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актууд.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг Говь-Угтаал сумын 2017-2020 оны бодлого төлөвлөлт, байгууллагуудын үйл ажиллагаа, тайлан, гэрээ, гэрээний хэрэгжилт, үйл ажиллагаанд аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, санхүүгийн баримт материалуудыг хамруулан шалгаж, баримтжууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлал, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу горим сорилыг гүйцэтгэн, нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

**Аудит хийх
багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:**

Аудитын үе шатны ажлыг дарга, тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Мөнхтогтох хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналт хэрэгжүүлэн, ахлах аудитор Т.Батсайхан, аудитор Ж.Угтахбаяр, Б.Гантуяа, Т.Оюун-Эрдэнэ, Л.Уранбилэг нар 2021 оны 5 дугаар сарын 05-ны өдрөөс 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдрийг дуустал хугацаанд аудитыг гүйцэтгэлээ.

Ерөнхий мэдээлэл

Говь-Угтаал сум нь 1941 онд Дундговь аймгийг анх байгуулагдахад Төв аймгаас 3900 гаруй хүн амтай 130 гаруй мянган толгой малтайгаар тасарч тус аймагт харьяалагдах болжээ. Тус сумыг 1963 онд Цагаандэлгэр сумтай нэгтгэж нэг сум болгосныг 1966 онд эргүүлэн тусгаарласан ба засаг захиргааны хувьд Ажирхай, Морьт, Хонгор гэсэн 3 багтай ба аймгийнхаа зүүн бүсийн тулгуур төвийн нэг юм.

Статистик мэдээгээр 2020 оны эцэст 1,555 хүн амтай, 498 өрхтэй, 201,727 толгой малтай байна.

Тус суманд тусгай зориулалтын шилжүүлгийн 2, улсын төсвийн 1, орон нутгийн төсвийн 3 байгууллага, тусгай зориулалтын сан 4, 34 аж ахуйн нэгж, байгууллага үйл ажиллагаа явуулж байна.

Сумын хэмжээнд нийт 107 төрийн албан хаагчийн орон тоо батлагдсанаас гүйцэтгэлээр 96 албан хаагч ажиллаж байна. Нийгмийн ажилтан, малын эмч, нягтлан бодогч, дотрын эмч, дархлаажуулалтын сувилагч, мэдээлэл зүйн багш зэрэг 11 ажлын байрны орон тоо сул байна.

Сумын сүүлийн 3 жилийн төсвийн орлогыг харьцуулахад 2020 оны төсөв нь 2,526.2 сая төгрөгөөр батлагдсан ба 2018 оноос 1,173.5 сая төгрөг, 2019 оноос 628.6 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Үзүүлэлт	Он			/сая төгрөгөөр/ Өсөлт/бууралт	
	2018	2019	2020	2020- 2018	2020- 2019
Татварын орлого	17.7	24.2	50.8	33.1	26.6
Татварын бус орлого	320.4	122.2	336.5	16.1	214.3
Тусламж, санхүүжилтийн орлого	1,014.6	1,751.2	2,138.9	1,124.30	387.7
Үйл ажиллагааны орлого	1,352.7	1,897.6	2,526.2	1,173.50	628.6

Эх сурвалж: Татварын хэлтсийн 2018-2020 оны татварын орлогын мэдээ

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын ХШҮДАХ-ээс Говь-Угтаал сумын Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж 2019 онд 83.1 хувь, 2020 онд 70.6 хувиар тус тус үнэлсэн байна. 2020 онд өмнөх оноос үнэлгээ буурсан шалтгаан нь байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ 46.2 хувиар үнэлэгдсэнтэй холбоотой байна.

Аудитаар нийт 33.8 сая төгрөгийн зөрчлийг илрүүлснээс 4.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 28.9 сая төгрөгийн албан шаардлага, 8 заалт бүхий зөвлөмж хүргүүлж, аудитын явцад 0.5 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлээ.

**Аудитын
илрүүлэлт:**

БҮЛЭГ 1

• СУМЫН БОДЛОГЫГ ЦОГЦ БАЙДЛААР ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

1.1 Сумын бодлогын баримт бичигт зорилго, зорилтоо оновчтой дэвшүүлээгүй байна.

Сумын Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр:

Сумын Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг сумын стратеги төлөвлөгөө, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан, 6 заалт бүхий 134 арга хэмжээг төлөвлөсөн байна.



Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төсвийн байгууллагуудын төлөвлөгөө хоорондын уялдаа болон сум, байгууллагын хөгжлийг тодорхойлж төлөвлөсөн эсэхийг харьцуулан судалгаа шинжилгээ хийлээ.

Жил бүрийн сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг 2017-2018 оны сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй, төсвийн байгууллагууд үйл ажиллагааны төлөвлөгөөгөө сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй уялдуулан төлөвлөсөн байна.

Харин сумын онцлог, давуу болон сул талд нөхцөл байдлын шинжилгээ хийж, тэргүүлэх ач холбогдлоор болон олон нийтээр хэлэлцүүлсэн асуудлуудыг эрэмбэлээгүй, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тусгасан бодлогын шинжтэй арга хэмжээнүүдийг төлөвлөөгүй байна.

Мөн сумын хөтөлбөр, үндсэн чиглэлд орсон зарим төсөл, арга хэмжээнүүд агуулгын хувьд давхардсан байна. /Тухайлбал: Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 3.6.5¹, 6.3.6² дахь арга хэмжээ./

Энэ нь ард иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцээгүй, сумын хөгжилд чиглээгүй төсөл арга хэмжээнүүд төлөвлөгдөх үр дагавартай байна.

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг төлөвлөхдөө шинээр батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийг удирдлага болгон ажлын байрыг бий болгож, иргэдийг ажилтай, орлоготой амьдрах таатай орчныг бүрдүүлэх, орон нутгийн төсөвт бодит хувь нэмэр оруулж чадахуйц төсөл, арга хэмжээг төлөвлөх нь зүйтэй байна.


¹ Ахмадын сувиалыг шаардлагатай тоног төхөөрөмж техник хэрэгслэлээр хангаж мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор үйл ажиллагааг нь тогтмолжуулна

² Ахмадын сувиалын барилгад урсгал засвар хийж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлнэ.

Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл:

Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд жил бүр 46-86 арга хэмжээг төлөвлөж, сумын ИТХ-ын тогтоолоор баталжээ. /Диаграмм №1/

Сүүлийн 4 жилд нийт 256 арга хэмжээг төлөвлөснөөс 37 хувь нь нийгмийн бодлогын, 23 хувь нь төрийн захиргаа, удирдлагын, 22 хувь нь дэд бүтцийн, 9 хувь нь ХХАА, газар тариалан, үйлдвэрлэлийн, 6 хувь нь санхүү, эдийн засгийн, 3 хувь нь байгаль орчин, аялал жуулчлал, уул уурхайн хүрээнд чиглэгдсэн байна.



Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа ажлын хэсэг томилоогүй, шаардлага хангасан судалгаа, шинжилгээг хийгээгүй байна.

Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт:

Говь-Угтаал сумын хүний нөөцийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах хөтөлбөрийг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 09 сарын 02-ны өдрийн 26 дугаар тогтоолоор баталжээ.

Суманд мэргэжлийн боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг сайжруулах зорилготой арга хэмжээнүүдийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Хүний нөөцийн бодлогын хүрээнд мэргэжлийн боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор сургалтын төлбөрийн хөнгөлөлт, сурч байх хугацааны цалин, боловсрол болон эрүүл мэндийн байгууллагуудын албан хаагчдад холбогдох хуулиудын дагуу олгогдох тэтгэмжүүдийг бүрэн олгожээ. Мөн өөр орон нутгаас шилжин ирж ажиллаж байгаа албан хаагчдыг орон байраар хангасан байна.

ОНХС-ийн төлөвлөлт:

ОНХС-ийн хөрөнгийг жил бүр иргэдээс санал авч эрэмбэлэн ИТХ-ын тогтоолоор батлан, хэрэгжүүлж ирсэн байна.

Аудитын хамрах хүрээнд ОНХС-аар хэрэгжүүлэх 37 төсөл, арга хэмжээг /давхардсан тоогоор/ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 28 төсөл, арга хэмжээ нь Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй, 13 төсөл, арга хэмжээ нь эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй тус тус нийцсэн байна.

Сүүлийн 4 жилд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнүүдийг эрэмбэлэхэд нийт төсвийн 61.9 хувийг хөрөнгө оруулалтын арга хэмжээнд зарцуулжээ.

/Хүснэгт 1/

Зориулалт	Он				Нийт дүн
	2017	2018	2019	2020	
Хөрөнгө оруулалт	7.0	45.0	66.7	131.5	250.2
Тоног төхөөрөмж	4.0	9.7	8.0	10.0	31.7
Төсөл, арга хэмжээ	46.9	23.7	15.2	18.6	104.3
Урсгал засвар	5.0	0.9	-	12.0	17.9
Дүн	62.9	79.3	89.8	172.1	404.1

Хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл арга хэмжээ нь гүний өрмийн худаг гаргах, өвс тэжээлийн хашаа барих, мал угаалгын ванн барих зэрэг ажлууд байгаа нь үйлдвэрлэл үйлчилгээ, ажлын байрыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болохуйц бодлогын шинж чанартай хөрөнгө оруулалтуудыг төлөвлөж чадаагүйг харуулж байна. Энэ нь иргэдийн амьдрах таатай орчин бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, орон нутгийн хөгжлийг дэмжих явцыг удаашруулах үр дагавартай байна.

Мөн иргэд жил бүр ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд нийтийн ахуй үйлчилгээний барилгыг ашиглалтад оруулах, халуун ус, үсчинг ажлуулах, ХХАА-н бүтээгдэхүүнийг боловсруулах цехтэй болох талаар саналуудыг өгсөн боловч уг ажлуудыг төлөвлөөгүй байна.

Иймд иргэдийн хэрэгцээ, шаардлагад тулгуурласан төсөл арга хэмжээг тэдний саналыг харгалзан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр төлөвлөх шаардлагатай байна.

Говь-Угтаал сум “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс сумын ОНХС-ийн үйл ажиллагаанд хийсэн жилийн гүйцэтгэлээр 2018 онд 55 хувьтай үнэлэгдэж 8.2 сая төгрөгийн, 2019 онд 53 хувьтай үнэлэгдэж 9.3 сая төгрөгийн урамшууллыг тус тус авчээ. Харин 2017 онд 32 хувь, 2020 онд 45 хувьтай хангалтгүй үнэлэгдсэн тул урамшуулалд хамрагдаагүй байна.

Аймгийн хэмжээнд 2017 оноос 2020 онд тогтвортой амьжиргаа төслөөс нийт 720.4 сая төгрөгийн урамшуулал олгосон байхад Говь-Угтаал сум 17.5 сая төгрөгийн урамшуулал авсан нь сумын ОНХС-ийн үйл ажиллагаа хангалтгүй, ажил хариуцсан албан хаагчийн санаачилгагүй, хариуцлагагүй ажилласныг харуулж байна.
/График №1/



Сумын жилийн гүйцэтгэлийн үнэлгээг аймгийн дундаж үнэлгээтэй харьцуулан графикаар харуулахад 2018 онд аймгийн дунджаас 5 хувиар их, бусад онуудад 7-19 хувиар бага үнэлэгджээ.

“Тогтвортой амьжиргаа-3” төслөөс сумын ОНХС-ийн үйл ажиллагаанд 6 бүлгээр үнэлгээ хийснээс олон нийтийн оролцоо, төсвийн ил тод байдал, төсвийн гүйцэтгэл, хяналт шинжилгээ үнэлгээ гэсэн 4 бүлгийн үнэлгээ хангалтгүй байгаагаас шалтгаалан урамшуулалд хамрагдаагүй байна.

Тогтвортой амьжиргаа-3 төслөөс боловсруулсан зааварчилгааны дагуу сумын ОНХС-ийн урамшууллыг тооцоолж үзэхэд 2017 онд 31.5 сая төгрөг, 2020 онд 12.2 сая төгрөг, нийт 43.7 сая төгрөгийн урамшуулал авах боломжтой байжээ.

Төсвийн тухай хууль болон Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан ОНХС-ийн үйл ажиллагааны журмыг мөрдөж, “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс сумын ОНХС-ийн үйл ажиллагаанд хийдэг жилийн гүйцэтгэлийн үнэлгээнүүдэд дүн шинжилгээ хийж, сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд анхаарч, санаачилгатай ажиллах шаардлагатай байна.

Сум хөгжүүлэх сан:

Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын дагуу зээлийн эргэн төлөлт, хүүгийн орлогоор бүрдүүлж байна. Сум хөгжүүлэх сангийн 2017-2020 оны хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл нийт 4,953.6 мянган төгрөг байгаа нь бусад сумдтай харьцуулахад үлдэгдэл бага, зээлийн эргэн төлөлтөд тавих хяналт сайн байна.


Тус сум иргэдийн Төлөөлөгчдийн хурлаараа “Сум хөгжүүлэх сангаас санхүүжих үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэхэд баримтлах чиглэл”-ийг жил бүр баталж байна. Харин сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаагүй байна.

1.2 Сумын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бодитой төлөвлөөгүй байна.

Татварын болон татварын бус орлого:

/График №2/

Сумын татварын орлогыг 2017-2020 оноор харьцуулахад сумын орлогын төлөвлөгөө жил бүр өссөн үзүүлэлттэй, аймагт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө буурсан үзүүлэлттэй, улсын төвлөрсөн орлогын төлөвлөгөөг 2020 онд 2.9 дахин нэмэгдүүлж төлөвлөсөн байна.



Сумын 2019 оны орлогын төлөвлөгөөг өмнөх оноос нийт дүнгээр 9.8 сая төгрөгөөр бууруулж баталжээ. Энэ нь бууны албан татвар, бусад орлогыг 0.4-14.2 сая төгрөгөөр бууруулж, улсын тэмдэгтийн болон хог хаягдлын хураамжийг 0.1-1.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсантай холбоотой байна.

Бууны албан татварыг 2018-2020 онд 1.1-0.7 сая төгрөг хүртэл жил бүр бууруулан төлөвлөсөн байхад гүйцэтгэлээр 0.1-1.4 дахин давж биелсэн нь тус орлогын төлөвлөгөөг нэмэгдүүлэх боломжтой бөгөөд татварын бааз суурьт тулгуурлан, төлөвлөх нь зүйтэй байна.

Сумын орлогын төлөвлөгөө нийт дүнгээр 2018 оноос бусад онуудад 115.6-136.5 хувиар биелж байгаа нь орлогыг нэмэгдүүлэн батлах боломж байгааг харуулж байна. Үйл

ажиллагааны орлого /ИОТТХ/ 2018 онд 31.5 хувиар тасарч бусад онуудад 127.1-150.4 хувиар давж биелсэн нь тухайн орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

Хувь хүний орлогын албан татварын хуулийн шинэчлэлийг хэрэгжүүлж, орлого нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

Аймагт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөг 2017 оноос жил бүр бууруулан баталсан нь хууль эрхзүйн өөрчлөлттэй холбоотой байна.

/График-3/ Тухайлбал:



- Цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татварыг 2018, 2019 онд өмнөх онуудаас 1.8-10.9 сая төгрөгөөр,
- Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 8.14-т заасны дагуу 2020 онд газрын төлбөрийн 40 хувийг сумын төвлөрсөн орлогод төвлөрүүлдэг болсонтой холбоотой өмнөх оноос 18.4 сая төгрөгөөр тус тус бууруулж баталсан байна.

/График-4/

Улсад төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг 2018 онд өмнөх оноос 5.1 сая төгрөгөөр бууруулж, 2019-2020 онд өмнөх оноос 20.5-284.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Энэ нь сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөлтэй уул уурхайн компани нэмэгдсэнээр ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг өсгөж төлөвлөсөн байна.



Төсвийн төлөвлөлт



Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Говь-Угтаал сумын төсөв захирагч нар 2017-2020 онуудад төсвийн төслөө тооцон төлөвлөж, төсөв захирагч нар нийт 7,337.3 сая төгрөгийн төсвийг төлөвлөн дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс 81.4 хувь нь батлагдсан байна.

/Хүснэгт 2/

Он	Төсвийн төсөл	Батлагдсан төсөв	Зөрүү	Хувь
2017	1,580.2	1,114.1	466.2	29.5
2018	1,744.8	1,281.7	463.1	26.5
2019	1,798.8	1,610.1	188.7	10.5
2020	2,213.5	1,967.1	246.3	11.1
Нийт дүн	7,337.3	5,973.0	1,364.3	18.6

Төсвийн төслийг жил бүр 10.5-29.5 хувиар бууруулан баталсан нь хөрөнгийн шинж чанартай хөрөнгө худалдан авах зардлыг өндрөөр төсөвлөсөнтэй холбоотой бөгөөд бодит нөхцөл байдалтай уялдуулахгүй, төсвийг бодитой төлөвлөхгүй байгааг илтгэж байна.

Мөн төсвийн байгууллагууд тухайн үеийн нөхцөл байдалтай хэрэгцээ шаардлагаа уялдуулаагүй төлөвлөснөөс шалтгаалжээ.

Улсын болон орон нутгийн батлагдсан төсөвт 2017-2020 онд хийсэн тодотголыг харьцуулахад орон нутгийн төсвийг нийт 138.4 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, тусгай зориулалтын шилжүүлэг болон улсын төсвийг нийт 28.0 сая төгрөгөөр бууруулан тодотгожээ.

/Хүснэгт 3/


Үзүүлэлт	Он	Батлагдсан төсөв	Тодотгосон	Өөрчлөлт	Хувь
Орон нутгийн төсөв	2017 он	232.1	297.2	65.1	28.1
	2018 он	254.9	289.9	35.1	13.8
	2019 он	302.5	321.4	18.8	6.2
	2020 он	535.7	555.1	19.4	3.6
Орон нутгийн төсвийн дүн		1,325.2	1,463.6	138.4	51.7
Тусгай зориулалтын болон улсын төсөв	2017 он	882.0	912.9	30.9	3.5
	2018 он	1,026.9	1,057.3	30.4	2.9
	2019 он	1,307.6	1,294.0	(13.6)	(1)
	2020 он	1,431.4	1,355.7	(75.8)	(5.3)
Улсын төсвийн дүн		4,647.9	4,619.9	(28.0)	0.1
Нийт дүн		5,973.1	6,083.5	110.4	51.8

Нийт тодотголын дийлэнх хувийг 2017 онд хийсэн тодотгол эзэлж байгаа нь тус онд байгууллагууд төвлөрсөн халаалтад холбогдож, түлш халаалтын зардал өссөн, тусгай зориулалтын шилжүүлэг болон улсын төсвийг Улсын Их Хурлаас “Ковид-19” цар тахлын нөлөөгөөр үүссэн эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан санхүүжилтийг 28.0 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын хувьд :

/График 5/

Орон нутгийн төсвийн байгууллагууд жил бүр батлагдсан төсвийг нэмж тодотгож байгаа нь төсвийг бодитой төлөвлөөгүйтэй холбоотой байна. Тодотголын дийлэнх хувийг тээвэр шатахуун, түлш халаалт, албан томилолт, урсгал засвар, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлууд эзэлж байна.



Улсын болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн хувьд:

/График 6/

Улсын болон тусгай зориулалтын шилжүүлгийн төсвийн байгууллагуудын 2017, 2018, 2019 онуудад өсөж, 2020 онд буурсан байна. Энэ нь 2020 онд гарсан цар тахлаас шалтгаалан улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин Засгийн газрын 2020 оны 05 дугаар сарын 168 дугаар тогтоолын дагуу тогтмол зардал, үдийн цай, хүүхдийн хоол, багаж хэрэгслийн зардал, дотоод албан томилолт, урсгал засварын зардлуудыг бууруулж, төсөвт тодотгол хийсэн байна. 2017-2020 онуудад байгууллагуудын санхүүгийн эх үүсвэрийг бодитой төлөвлөөгүйгээс жилд 1-2 удаа тодотгосон байна.



Иймд төсвийг цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан бодитой төлөвлөх шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөлт:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл арга хэмжээний саналыг 2017 онд хүргүүлээгүй, 2018 онд Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 6.2.4-т зааснаар суманд спорт зал барихаар тусгагдсаны дагуу иргэдийн эрүүл мэнд, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх шаардлагад нийцүүлэн спорт залны барилгын зураг төсвийг хийлгэж, саналыг хүргүүлснээр 2019 онд хэрэгжүүлэхээр батлагдсан байна.

Тус барилгын ажил 2019 онд эхэлж, гүйцэтгэгч компани барилгын суурийн ажлыг гүйцэтгэж, 500.0 сая төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

“Ковид-19” цар тахлын нөхцөл байдал, бараа материалын үнэ өсөлт зэргээс сүүлийн 2 жилд барилгын ажил зогсонги байдалтай байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд санхүүжүүлэх Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны барилга, хичээлийн байрны сантехникийн засварын ажлын саналыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн боловч зураг төсөв хийгдээд 2 жил өнгөрсөн тул эдийн засгийн тооцооллыг дахин хийлгэх шаардлагатай гэж үзээд саналыг БСШУЯ-нд хүргүүлээгүй байна.

БҮЛЭГ 2

• ДОТООД ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙГЭЭС БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.1 Удирдлага, зохион байгуулалт хангалтгүйгээс сумын үйл ажиллагааны хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх төлөвлөгөөг тусгаж өгөөгүйгээс хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх албан тушаалтан, нэгтгэн тайлагнах хугацаа, үнэлгээний үр дүн, санал зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа нь тодорхой бус байна.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудаас бүрэн хэрэгжээгүй 8 төсөл, арга хэмжээ байна. Үүнээс:

- Сумын төвийн ногоон байгууламжийн хашааг нэмэгдүүлж, өрх бүр мод тарих хөдөлгөөнийг өрнүүлэн төвийн ногоон байгууламжтай талбайг 10 га-д хүргэх;
- Ашиглагдахгүй байгаа барилга, байгууламжуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах;
- Сумын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөг иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулж батлагдсан төлөвлөгөөний дагуу сумын хөгжлийг төлөвлөнө гэсэн 3 төсөл, арга хэмжээг өөрсдийн идэвх санаачлага, нөөц бололцоонд тулгуурлан бүрэн хэрэгжүүлэх боломжтой байжээ.

Энэ нь үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтуудад нөхцөл байдлын шинжилгээ хийж, тэргүүлэх ач холбогдлыг эрэмбэлж боловсруулаагүй, шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэрийг бодитой тооцоолоогүйгээс шалтгаалжээ.

Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтууд бүрэн хэрэгжихгүй байгаа нь иргэдийн ажиллаж амьдрах таатай орчныг бүрдүүлэхгүй байх үр дагавартай байна.

Сүүлийн 4 жилийн сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг диаграммаар харуулвал:

/Диаграмм 2/



Нийт 207 арга, хэмжээ төлөвлөснөөс 57 хувь нь бүрэн хэрэгжсэн, 32 хувь нь хэрэгжих шатандаа, 3 хувь нь хэрэгжилт хангалтгүй, 5 хувь нь хэрэгжээгүй, 3 хувь нь хугацаа болоогүй байна.

Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг 2017-2019 оноор харьцуулав.

/График 7/



Жил бүрийн сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийг ИТХ-аар хэлэлцүүлэн 2017 онд 87.3 хувь, 2018 онд 84.5 хувь, 2019 онд 83.8 хувь, 2020 оны эхний хагас жилийн байдлаар 90.7 хувьтай үнэлсэн бол жилийн эцсийн хэрэгжилтийг үнэлсэн баримт байхгүй байлаа.

Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг цахим хуудсандаа мэдээлээгүй, олон нийтийн мэдээлэлтэй танилцах нөхцөлийг бүрэн хангаагүй байна.

/График 8/




Жил бүрийн Сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг ИТХ-аар хэлэлцүүлэн 2017 онд 87.7 хувь, 2018 онд 83.0 хувь, 2019 онд 88.8 хувь, 2020 оны эхний хагас жилийн байдлаар 90.1 хувьтай үнэлсэн бол жилийн эцсийн хэрэгжилтийг үнэлсэн баримт байхгүй байлаа.

ХШҮДАХ-ийн тайлан:

Харин аймгийн Засаг даргын Тамгын газрын ХШҮДАХ-ээс хийсэн хяналт-шинжилгээний үнэлгээний тайлангаар 2017 онд 89.2 хувь, 2018 онд 82.4 хувь, 2019 онд 69.6 хувьтай үнэлсэн байна.

Говь-Угтаал сумын Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний дүнг 4 жилийн байдлаар, аймгийн дундаж үнэлгээтэй харьцуулан графикаар харууллаа.

/График 9/



Графикаас харахад 2017, 2018 онуудад аймгийн дундаж үнэлгээнээс дээгүүр, 2019, 2020 онуудад буурсан үзүүлэлттэй байна. 2020 онд 70.6 хувьтай үнэлэгдэж өмнөх онуудаас болон аймгийн дундаж үнэлгээнээс огцом буурсан нь байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ 46.2 хувьтай,

хангалтгүй үнэлэгдсэнтэй холбоотой байна.

Иймд хяналт-шинжилгээний үнэлгээгээр хангалтгүй үнэлэгдсэн арга хэмжээнүүдийг сайжруулж, ХШҮДАХ-ээс өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн Засаг дарга, түүний Тамгын газрын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан ажиллах шаардлагатай байна.

Байгууллагуудын нөөц ашиглалт:



Байгууллагуудын хүчин чадлын ашиглалтыг харьцуулахад нийт хүчин чадлын 26-71 хувийг ашиглажээ.

- Ерөнхий боловсролын сургуулийн 80 хүүхдийн дотуур байр 21-42 хүүхэдтэй, 26.3-50.3 хувь, ашиглалт жил бүр буурсан;
- Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байр 320 хүүхдийн хүчин чадалтай, хичээлийн жилүүдэд 175-182 суралцагчтай, 54.7-56.9 хувьтай;
- Цэцэрлэг 100 хүүхдийн хүчин чадалтай 50-63 хүүхэдтэй ашиглалтын хувь тогтмол байснаа цар тахлын дэгдэлтээс шалтгаалан 2020 онд 28 хүртэл хувиар буурсан;
- Сум дундын эмнэлэг 7 ортой, ор ашиглалт нэг өдөрт 4-5 хүнтэй, 57.1-71.4 хувийн тогтмол ашиглалттай;
- Соёлын төв жилдээ 1,538-3,728 уншигчтай, 52-90 арга хэмжээ зохион байгуулсан, нэг арга хэмжээнд дунджаар 61-73 хүн хамрагдсан үзүүлэлттэй байсан бол 2020 онд 257 болж өсжээ. Энэ нь цар тахлын дэгдэлтээс шалтгаалан үйл ажиллагааг хязгаарласан ч Төрийн бус байгууллага, холбоодтой хамтран цахимаар төрөл бүрийн соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулж иргэдийг өргөн хамруулсантай холбоотой байна.

Энэ нь 2018 оноос хойш тус сумын айл, өрхийн тоо 39, хүн амын тоо 301-ээр тус тус буурсантай холбоотойгоор төсвийн байгууллагууд хөрөнгийн хүчин чадлыг бүрэн дүүрэн ашиглаагүй, сүүлийн хоёр жилд цар тахлын дэгдэлт байгууллагуудын үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлжээ.

Сумын төсвийн байгууллагуудад 2021 оны 5 дугаар сарын байдлаар 108 төрийн албан хаагчийн орон тоо батлагдснаас 98 албан хаагч ажиллаж байна. Байгууллага тус бүрээр батлагдсан орон тоо, гүйцэтгэл, дутагдалтай ажлын байрыг хүснэгтээр харууллаа.

/Хүснэгт 4/

№	Байгууллагын тоо	Орон тоо		Дутагдалтай ажлын байр	
		Батлагдсан	Гүйцэтгэл	тоо	нэр
1	ЗДТГ	20	16	4	Нийгмийн бодлогын мэргэжилтэн, малын эмч, нягтлан бодогч, төрийн сангийн мэргэжилтэн
2	ИТХ	2	2		
3	ЭМТ	29	24	5	Их эмч 2, нийгмийн эрүүл мэндийн ажилтан, дархлаажуулалтын сувилагч, эмийн санч
4	ЕБС	35	34	1	Сургуулийн эмч
5	Цэцэрлэг	16	16		
6	Соёлын төв	6	6		
	Дүн	108	98	10	

Дутагдалтай ажлын байран дээр сонгон шалгаруулалтыг зарласан боловч хүний нөөцийн хүрэлцээгүйгээс нөхөгдөөгүй байна.

Говь-Угтаал сумын хүний нөөцийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах хөтөлбөрийн хүрээнд 3 иргэнтэй гэрээ байгуулан сургалтын төлбөр 10.4 сая төгрөгийг орон нутгаас санхүүжүүлсэн байна. Уг гэрээний дагуу 2 албан хаагч сумандаа тогтвор суурьшилтай ажиллаж байна.

Харин Сум дундын эмнэлэгт их эмч бэлтгэх зорилгоор 1 иргэний сургалтын төлбөр 4.9 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлж, 5 жил тогтвор суурьшилтай ажиллахаар гэрээ байгуулжээ. Төгсөөд суманд ажиллаагүй тул 2016 оны 12 дугаар сард сургалтын төлбөрийг буцаан төлөх тухай гэрээг хийж, 0.5 сая төгрөгийг төлүүлсэн байна. Төлбөрийн үлдэгдэл 4.4 сая төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

Гэрээний дагуу буцаан төлсөн 0.5 сая төгрөгийг нярвын арилжааны банкны харилцах дансанд шилжүүлж, орон нутгийн төсвийн дансанд төвлөрүүлээгүй байсныг аудитын явцад зохих дансанд төвлөрүүллээ.

Сумын Засаг даргын Тамгын газар болон Ерөнхий боловсролын сургууль, Сум дундын эмнэлэг 2018 оноос хойш жил бүр орон тоо дутуу ажиллаж иржээ. Үүнээс шалтгаалан хавсран ажиллаж буй ажилтнуудын ажлын ачаалал ихсэн ажил цалгардах, хариуцлага сулрах байдал үүссэн байна.

Цаашид сумын ИТХ-аар баталсан “Хүний нөөцийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах хөтөлбөр”-ийн хүрээнд сул орон тоог нөхөх ажлыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

Гүйцэтгэлийн төлөвлөгөө:

Үр дүнгийн гэрээг /хуучин нэрээр/ Ерөнхий боловсролын сургуулиас бусад байгууллага 2017 онд 77.6-93.1 хувиар, 2018 онд 88.9-96.1 хувиар хэрэгжүүлж ажилласан байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хүснэгтээр харуулбал:

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт			
Байгууллагын нэр	2017	2018	2019
ЗДТГ	93.1	95.0	92.0
ЕБС	-	-	-

Соёлын төв	77.6	88.9	-
Цэцэрлэг	87.9	96.1	-

/Хүснэгт 6/

Сумын Засаг дарга 2020 онд байгууллагын удирдлагуудтай гүйцэтгэлийн төлөвлөгөө

Иймд Засгийн газрын 2019 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлагнах журам”-ыг хэрэгжүүлж, үр дүнг тооцож, ажлын хариуцлагыг сайжруулж ажиллах шаардлагатай байна.

байгуулаагүй нь ажлын үр дүнг тооцох боломжгүй, хариуцлагыг сулруулах үр дагавартай байна.

Сум хөгжүүлэх сан:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Сум хөгжүүлэх сангаас санхүүжих үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэхэд баримтлах чиглэл, төсөл сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөл, зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих ажлын хэсэг, хяналтын зардлыг жил бүр шинэчлэн баталж, үүрэгжүүлсэн байна.

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын дагуу 2018 оноос бусад онуудад 29 иргэн, 1 аж ахуй нэгжийн төслийг сонгон шалгаруулж нийт 216.2 сая төгрөгийн зээлийг олгосон байна.

Зээлийн эргэн төлөлт сайн байгаа боловч үйл ажиллагаа нь тогтворжсон, үйлдвэрлэл, үйлчилгээгээ өргөжүүлсэн жижиг дунд үйлдвэр эрхлэгчид байхгүй байна. Энэ нь ижил төрлийн төслийг сонгон шалгаруулдаг, олгож байгаа зээлийн хэмжээ төсөл хэрэгжүүлэгч нарын үйл ажиллагаа явуулахад хүрэлцдэггүйтэй холбоотой байна. Мөн сүүлийн 2 жил ковид-19 цар тахлын дэгдэлтээс шалтгаалан бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүндрэл үүсч байна.

Сум хөгжүүлэх сангийн зээл олголт журмын дагуу явагдаж, эргэн төлөлт хугацаандаа төлөгдөж байна. 2017 онд 1 хоршоо, 18 иргэнд 26.0 сая төгрөг, 2018 онд зээл олгоогүй, 2019 онд 3 иргэнд 35.0 сая, 2020 онд 8 иргэнд 69.0 сая төгрөгийн зээлийг олгон, эргэн төлөлт хуваарийн дагуу хэвийн явагдаж байна.


Харин 2 иргэний аудитаас тавигдсан төлбөрийн актын төлбөрийг барагдуулах ажлыг үе шаттай зохион байгуулж байна. Дээрх байдлаас дүгнэхэд тус сумын СХС-ийн зээл олголт, зээлийн эргэн төлөлт, авлага барагдуулалт журамд нийцэж байна.

Орон нутгийн хөгжлийн сан:

ОНХС нь аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгээс санхүүжилтийг жил бүр дутуу авсан байна. Энэ нь тус сангийн санхүүжилтийг Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас бүрэн ирүүлээгүйтэй холбоотой байна.

ОНХС-ийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгоогүй, жилийн эцэст бөөн олгосноос цаг хугацаа алдсан, сумын хөгжлийн

/График 10/



бодлогын баримт бичиг, үндсэн чиглэлд тусгагдаагүй, иргэдийн саналаар дэмжигдээгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн зөрчлүүд гарсаар байна. Тухайлбал иргэдийн саналаар дэмжигдээгүй 2018 онд 7.9 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ, 2020 онд 27.6 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг тус тус санхүүжүүлснийг өмнөх аудитуудаар албан шаардлага хүргүүлсэн байна.

Татварын болон татварын бус орлогын биелэлт:

/График 11/

Гүйцэтгэлээр сумын нийт орлого 2018 оноос бусад онуудад давж биелсэн, аймгийн нийт орлого эхний 2 жилд тасарч, улсад төвлөрүүлэх орлого 2019 оноос бусад онуудад биелээгүй байна.



Сумын төвлөрсөн нийт орлогын төлөвлөгөө 2017 онд 115.6 хувиар биелсэн боловч бууны албан татвар 50.4 хувиар тасарсан, 2018 онд сумын орлогын төлөвлөгөө 97.8 хувийн биелэлттэй байхад бууны албан татвар болон улсын тэмдэгтийн хураамж 82.6-126.5 хувиар давж биелсэн, 2019 онд сумын орлогын төлөвлөгөө 136.5 хувиар биелэсэн ч улсын тэмдэгтийн хураамж болон хог хаягдлын хураамж 25.8-49.7 хувиар тасарсан, 2020 онд 125.2 хувиар биелсэн ч хүү торгууль, бусад орлого 0.3-1.1 хувиар тасарсан. Үүнээс үзэхэд татварын орлого төрөл бүр дээр жигд биелэхгүй байна.

/График 12/



Аймгийн төвлөрсөн нийт орлогын төлөвлөгөөг 2017-2020 онд жил бүр бууруулан баталсан боловч 2019-2020 онуудад нийт орлого 39.4-51.3 хувиар давж биелсэн байна. Энэ нь цалин хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутгасан албан татварыг өмнөх онуудаас бууруулж баталсан ч дээрх онуудад 14.3-15.9

сая төгрөгөөр буюу 19.1-22.4 хувиар давж биелсэнтэй холбоотой байна.

/График 13/

Улсын төвлөрсөн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 2019 онд 677.5 сая төгрөг буюу 465.7 хувиар давж биелж, бусад онуудад 104.8-117.3 сая төгрөг буюу 25.0-93.9 хувиар тасарсан байна. Энэ нь 2017, 2018 онуудад тус суманд бүртгэлтэй уул уурхай компаниуд үйл ажиллагаа явуулаагүй, 2020 онд Рунто-Уул уурхай ХХК-ийн нийт орлого 6.0 тэрбум төгрөгт



хүрч том татвар төлөгчтэй харилцах газарт шилжиж улсын төсөвт ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг төвлөрүүлдэг болсонтой холбоотойгоор тус орлого тасарсан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт:

/Диаграмм 3/



Шилэн дансны тухай хуулийн дагуу сумын төсөвт байгууллагууд улс, орон нутгийн төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, нээлттэй, ил тод, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтмол оруулж байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд нийт 1,141 мэдээллийг оруулахаас 19 мэдээллийн хугацаа болоогүй, 1,079 мэдээллийг хугацаанд нь, 24 мэдээллийг хугацаа хоцорч, 19 мэдээллийг оруулаагүй байна. Хуулийн хэрэгжилт 96.2 хувьтай байна.

Мэдээлэл оруулаагүй байгууллагуудыг авч үзвэл Төсвийн ерөнхийлан захирагч 17, Засаг даргын Тамгын газар 1, Хүүхдийн цэцэрлэг 1 мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.

Төсөв захирагч нарт хугацаа хоцорсон болон мэдээлэл оруулаагүй тул 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар хугацаатай албан шаардлага болон зөвлөмжүүдийг тус тус хүргүүлсэн.

2.2 Дотоод хяналт хангалтгүйгээс аудитаар илэрч буй алдаа, зөрчил өссөн байна.



Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас орон нутгийн төсвийн байгууллагуудын 2017-2020 онуудад хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан санхүүжилтийг баталж, олгожээ.

Төсвийн байгууллагуудын батлагдсан төсөв, гүйцэтгэлийг сүүлийн 4 жилээр харьцуулахад улсын болон орон нутгийн төсвийн байгууллагуудад 94.8-100 хувь, тусгай зориулалтын сангуудад 31.9-70.7 хувийн санхүүжилтийг олгосон байна.

Хүснэгт 7/

№	Байгууллага	Тайлант он	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Дутуу авсан	Хувь
1	Орон нутгийн төсвийн байгууллага	2017 он	297.2	297.2	0.0	100
		2018 он	289.9	274.8	15.2	94.8
		2019 он	321.4	320.5	0.9	99.7
		2020 он	555.1	535.1	19.9	96.4
		Дүн	1,463.6	1,427.5	36.1	
2	Улсын төсвийн байгууллага	2017 он	912.9	909.7	3.2	99.6
		2018 он	1,057.3	1,056.0	1.3	99.9
		2019 он	1,294.0	1,291.1	2.9	99.8
		2020 он	1,355.7	1,325.8	29.8	97.8
		Дүн	4,619.9	4,582.6	37.3	
3	Тусгай зориулалтын сангууд	2017 он	285.6	201.9	83.7	70.7
		2018 он	274.5	88.8	185.7	32.4
		2019 он	409.6	130.7	278.9	31.9
		2020 он	508.6	242.7	265.9	47.7
		Дүн	1,478.3	664.1	814.2	
	Нийт		7,561.8	6,674.2	887.6	

Эх сурвалж: Сумын 2017-2020 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төсвийн байгууллагууд 2020 онд санхүүжилтийг дутуу авсан нь “Ковид-19” цар тахлын улмаас Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоож хүүхдийн хоол, үдийн цай, томилолт, хөрөнгийн зардлыг царцаасантай холбоотой байна.


Төсвийн зарцуулалт:



Төсвийн байгууллагууд төсвийг үр ашигтай,

хэмнэлттэй зарцуулсан ч аудитаар илэрсэн зөрчлийн агуулгын хувьд 2018 онд нягтлан бодох, бүртгэл, тайлагналтай холбоотой алдаа дийлэнх хэсгийг эзэлж байсан бол 2019, 2020 ондуудад хууль, тогтоомжтой холбоотой зөрчлүүд өссөн байна. Энэ нь илэрсэн алдаа, зөрчилд дүн шинжилгээ хийдэггүй, нягтлан бодогчийн орон тоо дутагдалтайгаас ажлын ачаалал их, дотоод хяналт хариуцсан ажилтнуудын хяналт хангалтгүйгээс шалтгаалжээ.

/График 14/



Аудитаар шүүхийн шийдвэрээр буцаж ажилдаа орсон албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг цалингийн зардлаас гаргаж авлагаар бүртгэсэн ч авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, холбогдох буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байна. Энэ нь Иргэний хуулийн 498.5³-д заасныг зөрчсөн тул холбогдох буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, төсвийг хохиролгүй болгох албан шаардлага хүргүүлээ.

Ерөнхий боловсролын сургууль 2018, 2019 онд дотуур байрыг бусдад түрээслүүлсний орлого 7,062.0 мянган төгрөгийн бүртгэлийн дансанд төвлөрүүлэлгүй, зориулалт бусаар зарцуулсныг таслан зогсоох, давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу нэмэлт санхүүжилтийн дансанд хандив, тусламж, дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан хөрөнгө, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 2017-2020 онуудад төвлөрүүлсэн орлогын эх үүсвэрийг хүснэгтээр харуулбал:

/Хүснэгт 8/

Үзүүлэлт	2017 он	2018 он	2019 он	2020 он	Дүн
Хандив, тусламжаар	-	4.0	25.7	6.5	36.2
Төсөв захирагчаас	48.1	25.2	40.8	35.5	149.6
Үндсэн үйл ажиллагаанаас	0.2	2.1	4.6	7.8	14.7
Нийт дүн	48.3	31.2	71.1	49.8	200.5

³ Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй

Нэмэлт санхүүжилтийн дансанд 200.5 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 74.6 хувийг дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан хөрөнгө, 18.0 хувийг хандив тусламж, 7.4 хувийг төсвийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого эзэлж байна. Нийт 36.2 сая төгрөгийн хандив, тусламжийн орлогыг төвлөрүүлснээс 2019 онд 25.7 сая төгрөгийг төвлөрүүлэн бүртгэсний дийлэнх нь тус онд зохион байгуулагдсан “Турван мянган уртын дууч, морин хуурчдын урлагийн наадам”-д зориулан иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас өгсөн хандив байна.

Нэмэлт санхүүжилтээс 185.2 сая төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 15.3 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ. Зарцуулалтыг зардлын үзүүлэлт тус бүрээр харуулбал:

/Хүснэгт 9/

Үзүүлэлт	2017 он	2018 он	2019 он	2020 он
Нормативт зардал	0.7	-	4.0	0.4
Эд хогшил, урсгал засварын зардал	-	1.4	0.7	4.2
Томилолт, зочны зардал	12.9	-	1.2	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-	-	0.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2.0	0.4	3.8	6.4
Бараа үйлчилгээний бусад зардал	22.9	13.7	46.3	13.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1.0	2.0	0.6	2.7
Хангамж, бараа материалын зардал	8.8	13.8	14.6	7.1
Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	0.0	0.0	15.3
Зарцуулалтын дүн	48.3	31.3	71.1	49.8

Нийт зардлын 51.9 хувийг бараа үйлчилгээний бусад зардал эзэлж байгаа бөгөөд дээд шатны төсөв захирагчаас хуваарилсан хөрөнгийн зарцуулалт байна. Тухайлбал Үндэсний статистикийн хорооноос хүн ам, малын тооллогын зардал, ХХААГ-аас үлийн цагаан оготнын устгалын зардлууд зэрэг байна. Зардлын өсөлтийг харахад 2019 онд 71.1 сая төгрөгийн санхүүжилтийг авсан нь “Турван мянган уртын дууч, морин хуурчдын урлагийн наадам”-ыг аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан зардлыг эх үүсвэрийг төвлөрүүлж, зарцуулсантай холбоотой.

2.3 Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт хангалтгүй байна.



/Диаграмм 4/

Говь-Угтаал сумын төсвийн байгууллагуудын үндсэн хөрөнгө 2020 оны эцэст 2017 оны эхний үлдэгдлээс 33.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Үндсэн хөрөнгийн өсөлтийг эх үүсвэрээр харьцуулан харуулбал:




Үндсэн хөрөнгийн 35 хувийг хандиваар бэлтгэсэн хөрөнгө, 13 хувийг төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн байна.

Аудитын хамрах хугацаанд хандиваар 352.6 сая төгрөгийн хөрөнгийг бэлтгэснээс 71.6 хувийг 2020 онд, үүний 75.8 хувь

ЗДТГ-т нэмэгдсэн хөрөнгө эзэлж байна.

/График 15/



Мөн үндсэн хөрөнгийн бууралтыг төрлөөр нь харьцуулан харууллаа.

Аудитын хамрах хугацаанд үндсэн хөрөнгө 2,517.6 мянган төгрөгөөр буурсны 65.5 хувь нь 2018 онд төсвийн байгууллагууд хөрөнгийн дахин үнэлгээ хийсэнтэй холбоотойгоор буурчээ.

Үндсэн хөрөнгийн ашиглалт:

Сумын хэмжээнд нийт 227.0 сая төгрөгийн хөрөнгө ашиглалтгүй байна. Үүнээс:

- Ерөнхий боловсролын сургуулийн 1988 онд ашиглалтад орсон 80 хүүхдийн дотуур байранд аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2018 онд улсын байцаагчийн “засвар хийх шаардлагатай” гэсэн дүгнэлт гарсан. Ашиглах боломжгүйгээс дотуур байрны сурагчдыг Засаг даргын Тамгын газарт бүртгэлтэй ахмадын сувиллын барилгад байрлуулан үйл ажиллагаа явуулсан байна.
- Цэцэрлэг шарах шүүгээ, хэвлэгч машиныг огт ашиглаагүй байна. Эдгээр нь 2013 онд БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар ирсэн бөгөөд тус байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалтаас шалтгаалан 2014 онд ашиглалтад орсон шинэ цэцэрлэгийн барилгыг баригдаж дуусахаас өмнө шарах шүүгээг суурилуулаагүйгээс барилгын хаалга, цонхоор оруулах боломжгүй болсон, харин хэвлэгч машины тохиргоог хийж чадахгүй, удаан хугацаанд ашиглаагүйгээс хор нь хатаж шинээрээ ашиглах боломжгүй болжээ.

Энэ нь хөрөнгийн үр өгөөжийг бууруулах, хөрөнгийн зардлыг нэмэгдүүлэх үр дагавартай байна.

Харин бусад хөрөнгийг хэрхэн шийдвэрлэх, яаж ашиглах талаар тодорхой бодлого, төлөвлөгөө байхгүй байна. Иймд мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах, бусад зориулалтаар ашиглах хэрэгцээ шаардлага, шийдвэрлэх боломж, ашиглалтын зардал, эдийн засгийн үр өгөөжийг цогцоор нь судалж шийдвэрлэх нь зүйтэй.



Ерөнхий боловсролын сургуулийн ашиглагдаагүй сурах бичгүүд нь 2009-2015 онд хэвлэгдсэн дахин ашиглагдах эсэх нь тодорхойгүй нийт 3,224 ширхэг ном байгаа нь овор багтаамж ихтэйгээс гадна хадгалах, жил бүр тоолох зэргээр хүндрэл үүсгэдэг байна.

ОНХС-ийн хөрөнгөөр авсан 6.7 сая төгрөгийн 35 толгой баяд хуц 2019-2020 онуудад хорогдож дууссан байна.

Анх авахдаа малчиндаа хүлээлгэж өгсөн гэрээ, бичиг баримт байхгүй, хуц тавьснаар

бий болох үр ашгийг тооцож үзсэн тооцоо судалгаа байхгүй, хуцыг маллаж байсан 2 малчинд ажлын хөлсний өртэй, ажлын хөлсний өрийг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байна.

Үүнээс үзэхэд орон нутагт зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалтуудыг оновчтой тодорхойлон хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллаж чадаагүй байна.

Хөрөнгийн бүртгэл, тооллого, тооцоо:

Говь-Угтаал сумын төсвийн байгууллагуудын хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй байна. Тухайлбал ихэнх төсвийн байгууллага 2019, 2020 онд эхний хагас жилийн хөрөнгийн тооллого хийж тооцоо бодоогүй, 2020 оны жилийн эцсээр тооллого хийсэн ч тооцоо бодож хөрөнгийн үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулаагүй, Ерөнхий боловсролын сургууль 2019, 2020 онд агуулахын бүртгэл, эд хариуцагчийн карт огт хөтлөөгүй байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4⁴, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2⁵-д заасныг тус тус зөрчсөн. Иймд зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

Мөн тус сумын төсвийн байгууллагууд хөрөнгийн тооллого хийсэн ч илтгэх хуудас бичдэггүй, акталж устгасан хөрөнгийн устгалын акт үйлдэж баримтжуулдаггүй нийтлэг дутагдал байна. Энэ нь төсөв захирагч нар тооллогын комиссыг ёс төдий томилдог, томилсон ч үүрэгжүүлдэггүй, хөрөнгийн тооллогын үр дүнд ач холбогдол өгдөггүйгээс тооллогын комиссын ажлын хариуцлагыг сулруулдаг үр дагавартайг анхаарах нь зүйтэй.

Аудитын явцад барилга байгууламж, тээврийн хэрэгслийн хувийн хэрэг хөтлөлтийг хянаж үзэхэд Сум дундын эмнэлгээс бусад байгууллага хувийн хэргийг бүрэн хөтлөөгүй, хөрөнгөнд хийсэн их болон урсгал засвар, хөрөнгийн дахин үнэлгээ хийсэн тухай тэмдэглэл, тээврийн хэрэгслийн улирал бүрийн гүйлт, зарцуулсан шатахуун, тавьж олгосон сэлбэг хэрэгслийн тэмдэглэл зэргийг хийгээгүй, Ерөнхий боловсролын сургууль, Засаг даргын Тамгын газраас шилжүүлэн авсан тээврийн хэрэгсэл огт хувийн хэрэг байсангүй.



Орон нутагт үйл ажиллагаа явуулдаг Шанжин орд ХХК-ний хандиваар 2018 онд ашиглалтад орсон 12 айлын 3 давхар орон сууцны барилга, ОНХС-ийн хөрөнгөөр авсан баяд хуцыг орлогод авч бүртгэл тайланд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73.2-т заасныг тус тус зөрчсөн. Иймд хандиваар бий болсон орон сууцны барилгын холбогдох баримт материалыг бүрдүүлэн, орлого авч, санхүүгийн тайланд тусгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

Харин 12 айлын орон сууцнаас Сум дундын эмнэлэг 1 айлын орон сууцыг 55.0 сая төгрөгөөр бүртгэлд авч тайланд тусган эзэмшиж байгаа бол Засаг даргын Тамгын газар 5

^{4 4} /Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна/

^{5 5} /Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана/

айлын орон сууцыг хөрөнгийн дансанд орлогодож аваагүй тайлан бүртгэлд тусгаагүй боловч түрээсийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна.

Аудитын явцад Мал хамгаалах сангийн өвсний зарцуулалтыг давтан тооцоолоход нийт дүнгээр 7.4 сая төгрөгийн зөрүүтэй байлаа. Давтан тооцооллоор хийсэн өвсний тайлангийн нэгтгэлээс харахад нэг бүр нь 8.0 мянган төгрөгийн үнэтэй шинэ өвсний зарлага орлогоосоо 144-өөр илүү буюу 1.2 сая төгрөгийн хасах үлдэгдэлтэй гарч байгаа, 2020 оны 7 сарын нярвын тайлангийн өвсний эхний үлдэгдэл өмнөх сарын үлдэгдлээс зөрүүтэй байгаа зэрэг нь тайлан тооцоо алдаатай, баримт материал бүрэн бус байгааг нотолж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5, 20.2.6 дахь заалтуудыг тус тус зөрчсөн тул өвсний тооцоог 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хөөж нөхөн бодож баримтжуулах, зөрүү гарсан тохиолдолд хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэхээр хугацаатай албан шаардлага хүргүүлж, тооцоог тулган шалгах, тайланг залруулах, нотлох баримтыг бүрдүүлэх талаар холбогдох албан тушаалтнуудад зөвлөмж өглөө.

Эдгээрээс үзэхэд Говь-Угтаал сумын хэмжээнд хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт хангалтгүй бөгөөд энэ нь ажил хариуцсан санхүүгийн ажилтнуудын хариуцлагагүйгээс шалтгаалж байна. Энэ нь тайлан мэдээ зөрөх, буруу гарах, хөрөнгө үрэгдэх солигдох эрсдэлтэй нөхцөлийг бүрдүүлж, байгууллагын дотоод хяналт сулрах үр дагавартай байгааг анхаарах шаардлагатай байна.

Өмч хамгаалах байнгын зөвлөлүүдийн үйл ажиллагаа:

Говь-Угтаал сум 2017 онд төсвийн байгууллагуудын хөрөнгийг цэгцлэх сарын аян зохион байгуулж 2017 оны 5 дугаар сарын 02-ны өдөр байгууллагуудын ажлын тайланг хэлэлцсэн байна. Энэ ажлын хүрээнд төсвийн байгууллагуудын хөрөнгийг тоолж, ашиглалтгүй хөрөнгүүдийн судалгааг гаргуулах, зарим хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, ашиглах боломжгүй хөрөнгийг данс бүртгэлээс хасаж устгах, эмхэлж цэгцлэх ажлууд хийгдсэн нь зохих үр дүнгээ өгчээ.

Төсвийн байгууллагуудаас Цэцэрлэгийн өмч хамгаалах зөвлөл жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулсан, хийсэн ажлаа жилд нэг удаа тайлагнасан бол бусад байгууллагын өмч хамгаалах зөвлөл тодорхой ажил хийгээгүй байна.

Хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, хөрөнгийн анхан шатны буюу нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн байдлаас үзэхэд сумын болон төсвийн байгууллагуудын өмч хамгаалах зөвлөл нь хөрөнгийн хөдөлгөөн гарахад материал бүрдүүлэх төдийгөөр үйл ажиллагаа нь хязгаарлагдаж, хяналт тавих үйл ажиллагаа суларсан нь сумын хэмжээгээр хөрөнгө эзэнгүйдэх үр дагавартай байна.

Иймд Өмч хамгаалах зөвлөлийн ажлыг идэвхжүүлэх, зөвлөлийн гишүүдийн ажлыг ажил дүгнэх үзүүлэлтэд оруулж үр дүнг тооцдог болох, зөвлөлийн гишүүдийн мэдлэг ур чадварыг сайжруулах, хөрөнгийн ашиглалтын байдалд үнэлэлт өгдөг, худалдан авах хөрөнгийн хэрэгцээ шаардлага, зах зээлийн үнийн судалгаа хийж арга зүйн зөвлөгөө өгөх түвшинд хүртэл чадваржуулж, хариуцлага хүлээдэг болгох шаардлагатай болжээ.

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

ДОТООД ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙГЭЭС СУМЫН БОДЛОГЫГ ЦОГЦ БАЙДЛААР ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

СУМЫН БОДЛОГЫГ ЦОГЦ БАЙДЛААР ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨӨГҮЙ БАЙНА.

1.1 Сумын бодлогын баримт бичигт зорилго, зорилтоо оновчтой дэвшүүлээгүй байна.

1.2 Сумын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг бодитой төлөвлөөгүй байна..

ДОТООД ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨГҮЙГЭЭС БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

2.1 Удирдлага, зохион байгуулалт хангалтгүйгээс сумын үйл ажиллагааны хэрэгжилт үр нөлөөгүй байна.

2.2 Төсвийн эх үүсвэрийг бүрэн авсан ч дотоод хяналт хангалтгүйгээс аудитаар илэрч буй алдаа, зөрчил өссөн байна.

2.3 Хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад тавих хяналт хангалтгүй байна.

Зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн холбогдох албан тушаалтан, байгууллагад дараах зөвлөмжүүдийг өгч байна.

Сумын Засаг даргад:

1. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг төлөвлөхдөө орон нутгийн хүн, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн орон нутгийн хөгжлийн зорилтуудтай уялдуулж, зорилт, арга хэмжээг санхүүжилтийн эх үүсвэр, жил бүрийн задаргаагаар боловсруулан гаргах;
2. Байгууллагуудын дарга нартай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөг “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлагнах журам”-ын дагуу баталж, үр дүнг тооцож, ажлын хариуцлагыг сайжруулах;
3. Сумын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан арга хэмжээг хэрэгжүүлж, мэдээлэл түгээх олон талын сувгийг ашиглан, иргэдийг мэдээллээр хангаж ажиллах;
4. ИТХ-аар баталсан “Хүний нөөцийг хөгжүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах хөтөлбөр”-ийн хүрээнд сул орон тоог нөхөх ажлыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, ажилтнуудын ажлын хариуцлагыг нэмэгдүүлж ажиллах;
5. “Тогтвортой амьжиргаа-3” төслөөс сумын ОНХС-ийн үйл ажиллагаанд хийдэг жилийн гүйцэтгэлийн үнэлгээнээс хангалтгүй үнэлэгдсэн арга хэмжээнүүдэд дүн шинжилгээ хийж, сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
6. Өмч хамгаалах зөвлөлийн ажлын төлөвлөгөөг баталж хөрөнгийн ашиглалт, бүртгэл, тооллого тооцоонд тавих хяналтыг сайжруулж, ажлын тайланг хэлэлцэн үр дүнг тооцож, хариуцлагажуулах.

Орон нутгийн өмчийн газарт:

1. Говь-Угтаал сумын хөрөнгийн ашиглалт, өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт хийж, ашиглалтгүй хөрөнгийг зохих журмын дагуу шийдвэрлэх ажлыг сумын удирдлагатай хамтран хэрэгжүүлэх

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст:

1. Сумын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийхдээ байгууллагуудын удирдлагатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ажил дүгнэх үзүүлэлтэд оруулж үнэлэх;

Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст:

1. Говь-Угтаал сумын төрийн албан хаагчдад бодлогын баримт бичиг боловсруулах, зорилтуудыг уялдаа холбоотой төлөвлөх, хэрэгжилтийн үр дүнг тооцож тайлагнах чиглэлээр сургалт зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгч чадавхжуулах;

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

Т.БАТСАЙХАН
Ж.УГТАХБАЯР
Т.ОЮУН-ЭРДЭНЭ
Б.ГАНТУЯА
Л.УРАНБИЛЭГ

Шалгагдагч байгууллагын санал тайлбар



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГА

48070 Дундговь аймаг, Говь-Угтаал сум

3 дугаар баг, Хонгор

Утас: 9847-3034

И-мэйл: govugttaal@dundgovi.gov.mn

2021-08 № 1/6246
танай _____-ны № _____-т

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР-Т

Тус сумын “Бодлого төлөвлөлт түүний хэрэгжилт үр дүн”-д хийсэн аудитын тайлангийн хэрэгжилттэй танилцлаа.

Төрийн албан хаагчдын ажилдаа хариуцлагагүй хандсан байдал орон тооны дутагдалтай байдал зэргээс шалтгаалан төлөвлөсөн ажил хэрэгждэггүй явцын хяналт шалгалт дутуу хийгдсэн, төлөвлөгөө гаргаж ажиллаагүй зэрэг зөрчил дутагдал байна.

Аудитын шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХАМГАЛАН

Тайлан баталгаажуулах тушаал



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2021 оны 09 сарын 01 өдөр

Дугаар А/24

Мандалговь

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.1, 1.3, 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Говь-Угтаал сумын бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан /ДУА-2021/82-ШТА-ГА/-г баталсугай.
2. Аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалт (акт, албан шаардлага, зөвлөмж)-ийг хавсралтаар баталсугай.
3. “Говь-Угтаал сумын бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг Говь-Угтаал сумын Засаг даргад хүргүүлсүгэй.
4. Гүйцэтгэлийн аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2021 оны 12 дүгээр сарын 10-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг Говь-Угтаал сумын Засаг дарга /Ө.Мөнх-Амгалан/-д зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг санхүүгийн аудитын албаны ахлах аудитор /Т.Батсайхан/-д үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Р.МӨНХТОГТОХ



0012010078

Монгол Улс, Дундговь аймаг 48090, Сайнцагаан сүм, Нарлаг
баг, Нутгийн удирдлагын ордон Утас/Факс: 70-59-24-39
E-mail: dundgovi@audit.gov.mn 